



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 588

Улаанбаатар хот

Өмчлөгчийн эрхийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1, 43 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 51 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 319 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдааны тэмдэглэл, Монгол Улсын иргэн Дашийн Сайнхүүтэй байгуулсан 01 дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ”-ний 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр баг, 2 дугаар хорооллын нутаг дэвсгэрт байрлалтай “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй компанийн эзэмшлийн 500 м2 газар бүхий амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын нээлттэй дуудлагын худалдааны ялагч Дашийн Сайнхүү нь нийт 110,200,000.00 (нэг зуун арван сая хоёр зуун мянган) төгрөгийг хууль болон гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж гэрээний 3.1-д заасан үүргээ биелүүлсэн тул иргэн Дашийн Сайнхүүд дээрх дуусаагүй барилгын өмчлөх эрхийг, эзэмшил газрын хамт шилжүүлэн олгосугай.

2. Иргэн Дашийн Сайнхүүд өмчлөх эрхийн гэрчилгээ олгохыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Дуусаагүй барилгыг эзэмшил газрын хамт иргэн Дашийн Сайнхүүд гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан нарт даалгасугай.

4. Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр баг, 2 дугаар хорооллын нутаг дэвсгэрт байрлалтай “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй компанийн эзэмшлийн 500 м2 газар бүхий амины орон сууцны зориулалттай дуусаагүй барилгын хувьчлалын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, батлуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Д.Одмаад үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132005782
21-r huraldaan.docx